



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран ажиллах 81033483 дугаартай гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах” ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах ажлыг батлагдсан гэрээний загварын дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэхийг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс /П.Оюунцэцэг/-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД




Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal


080974

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 07 сарын 29 өдрийн
28.1 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



“БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: П.Оюунцэцэг, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын, /ЭМБХЗГ/ Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн /НЭМХ/ дарга
- Нарийн бичгийн дарга: Ц.Хандармаа, ЭМБХЗГ-ын НЭМХ-ийн мэргэжилтэн
- Гишүүд:
- Т.Баярсайхан, Стратеги бодлого төлөвлөлтийн газрын, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
 - Б.Пүрэвжав, ЭМБХЗГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн
 - Б.Цогтбаатар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал
 - О.Чимэдсүрэн, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал
 - С.Юндэн, Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга
 - С.Өнөрсайхан, НЭМХ-ийн Хор судлалын секторын эрхлэгч
 - Д.Баатарцол, Хор судлалын лабораторийн эрхлэгч
 - Д.Сагараадорж, Уул уурхайн яамны харъяа АМГ-ын Бичил уурхайн тасгийн дарга /зөвшилцсөнөөр/
 - Н.Нарантөгс, Монголын бичил уурхайчдын дээвэр холбооны тэргүүн /зөвшилцсөнөөр/
 - Г.Бурмаа, Хөдөлмөрийн эрүүл мэндийн судалгааны төвийн дэд захирал
 - М.Энхбат, Тогтвортой бичил уурхай төслийн ХАБЭА мэргэжилтэн



**“БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

Үндэслэл:

Зорилго:

Бичил уурхайчид ихээр амьдардаг орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтныг чадахуулах, уурхайчид болон тэдний гэр бүлийнхний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлж, нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангахад оршино.

Зорилт:

1. Бичил уурхайчид ихээр амьдардаг орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтныг чадахуулах
2. Уурхайчид болон тэдний гэр бүлийнхний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх

Үйл ажиллагааны чиглэл:

- Ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулах
- Химийн хордлого, ажлын байрны эрсдэлээс өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах, сэргийлэх сургалтын хөтөлбөр, сургалтын материал, гарын авлагыг боловсруулах, хэлэлцэх, батлуулах
- Сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулах багш нарыг сонгох
- Бичил уурхайчид ихээр амьдардаг орон нутгийн эмнэлгийн ажилтнуудад мэргэшлээс шалтгаалах өвчин, химийн хордлого, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, ажлын байрны эрсдэл, түүнээс сэргийлэх арга зүйн сургалтад хамруулах сургалтын хөтөлбөр, сургалтын материал боловсруулах, хэлэлцэх, батлуулах
- Бичил уурхайчид ихээр амьдардаг орон нутгийн эмнэлгийн ажилтнуудад сургалт зохион байгуулахад удирдлага, арга зүйгээр хангах
- Бичил уурхайчид ихээр амьдардаг орон нутгийн эмнэлгийн ажилтнуудад мэргэшлээс шалтгаалах өвчин, химийн хордлого, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, ажлын байрны эрсдлийг үнэлэх судалгаа хийх арга зүйг хэлэлцэх
- Хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх
- Тайлагнах арга хэмжээ авах

Үр дүн:

1. Бичил уурхайчид ихээр амьдардаг орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтан чадавхи дээшилж, бичил уурхайчид болон тэдний гэр бүлийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ сайжирна.
2. Уурхайчид болон тэдний гэр бүлийнхний эрүүл мэндийн боловсрол дээшлүүлж, эрсдлээс өөрсдийгөө хамгаалах мэдлэг, ойлголттой болно.
3. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай болно.